

Сэдвийн хураангуй

СЭДЭВ: АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫГ ИДЭВХИЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА

ОРШИЛ

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт, оролцооны талаарх үзэл баримтлал

Олон нийтийн оролцоог идэвхижүүлж буй зарим орны туршлагаас

Нэгдүгээр дэд сэдэв: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцох оролцооны өнөөдрийн байдал, шийдвэрлэх асуудал

Хоёрдугаар дэд сэдэв: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналтыг идэвхижүүлэх зарим арга

Хавсралт дэд сэдэв: Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хэрэгжилт, түүний тусгал

ДҮГНЭЛТ

Ашигласан материалын жагсаалт

ОРШИЛ

Хуулийн зөрчилтэй тэмцэх, авлигын гэмт явдлыг таслан зогсоох нь зөвхөн хууль сахиулах байгууллагын л үүрэг мэтээр бид ойлгодог. Гэтэл энэ үйл ажиллагаа нь дан ганц хууль сахиулах байгууллагын үүрэг төдийгүй иргэд, олон нийт, нийгмийн оролцох ёстой үүрэг юм байна. Учир нь иргэд, олон нийт, нийгмийн дунд өрнөж буй үйл явдлыг тэд аливаа хууль сахиулахын байгууллагаас илүү ажиглаж, мэдэж байдаг. Тэрхүү мэдээллээ хууль зүйн үүднээс үнэлж, дүгнүүлэх үүднээс холбогдох хуулийн байгууллагатай хамтарч **ажиллах шаардлага үүсч байна.**

“Хууль сахиулах, хуулийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэг нь дан ганц хууль сахиулах байгууллагын үүрэг байдаг” гэсэн нийгэмд тогтсон ойлголт хэв шинжээс **“хуулийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэг нь иргэн, олон нийт, нийгмийн зайлшгүй үүрэг”** юм гэдэг ойлголтод шилжих нийгмийн сэтгэл зүйн статуст шилжих шилжилтэд бэлтгэх онол, олон нийтийн дундах сурталчилгааг гүйцэтгэх цаг үе ирээд байна.

Нийгэмд шинэ үзэл санаа ойголт төрүүлэх, түүнийгээ түгээн дэлгэрүүлэхэд түүний суурь онол, философи, үзэл баримтлал, номлол сургаал зайлшгүй шаардлагатай байдаг.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулахад нийгмийн үүргийг нь иргэд, олон нийтэд танилцуулан ойлгуулах нь судлаачдын үүрэг бөгөөд энэхүү үзэл санаа, үзэл баримтлалын номлол сургаал, эшлэлийг бүрдүүлэх нь зүйтэй гэсэн онолын аргументийг дэвшүүлж байгаа юм.

Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах үйл ажиллагаанд хамаарах ухагдахууны номлол, сургаал нь үүнтэй холбоотой баримтууд, жишиг аксиом, эшлэл нотолгоо зэргээс бүрдэж болох ба энэ нь цаашдаа баяжих юм. Ингээд нэр томьёоноос эхэлье.

Нэр томьёо:

Авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн үйл ажиллагаа гэж: авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн өмнөх нээлттэй эрх, үүрэг, соён гэгээрүүлэх, авлигын эрсдэл, тохиолдол, болзошгүй нөхцөл байдлыг мэдээлэх, шалгах, мөрдөх, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хүсэлт, гомдол, санал өгөх зэрэг олон талын үйл ажиллагааг,

Олон нийт гэж: Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, төрийн ба төрийн бус байгууллага, хууль сахиулах байгууллагад авлигатай холбоотой мэдээлэл өгч, иргэний нийгмийн хяналт хэрэгжүүлэх боломж бүхий нийгмийн гишүүнийг,

Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналт гэж: авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажилагаанд олон нийтийн зүгээс мэдээлэл/өргөдөл, гомдол, хүсэлт/ өгөх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, бүтээл туурвих, авлигын эсрэг үйл ажиллагаанд соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, сайн дурын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хуульд харшлахгүйгээр хувийн мөрдөлт/папараци/ хийх болон бусад энэ чиглэлийн үйл ажиллагааг,

Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн хяналт гэж: авлигын эрсдэл, болзошгүй нөхцөлд болон авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, шалгах, мөрдөх, хянан шийдвэрлэх үеийн аль ч шатанд олон нийтийн зүгээс зохих түвшинд оролцох үйл ажиллагааг хэлнэ, ингэхдаа: сошиал сувгаар үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл мэдээлэл дөрөвдэх засаглалын оролцоо, нийгэмд шуугиан тарьсан хэргийн шийдвэрлэлтийн явцад нийгэмд нээлттэй асуулга тавих, авлигын эрсдэл бүхий субъектыг шууд хянах/папараци, бусад тандалт/

Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн хяналт оролцоог идэвхижүүлж буй зарим гадаад орны туршлагаас:

Киргиз улсад Авлигын талаар мэдээл өгсөн хүнийг хамгаалах хуулийн зохицуулалт бий болгожээ. Түүнчлэн зөвхөн хамгаалаад зогсохгүй гурван жилийн хугацаанд ажлаас нь халахыг хориглосон байна.

БНСУ-д “Ранын хууль” хэмээн хууль санаачлагийнх нь нэрээр нэрлэсэн хууль батлагдсан байна. Энэ нь авлигын эсрэг мэдээлэл өгөх олон нийтийн үйл ажиллагааг маш хүчтэй дэмжсэн, мэдээллийг худалдаж авахаар 200 000 000 вон хүртэл үнэлсэн, авлигын эрсдэл бүхий субъектүүдийг мөрдөх хувийн мөрдөлтийн эрх олгосон, тэдний үйл ажиллагаанд аргазүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх хууль зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Мөн түүнчлэн Өмнөд Азийн болон Европын зарим улс орнуудад авлигын эсрэг мэдээлэл өгсөн, эрх бүхий байгууллагатай үр дүнтэй хамтарч ажилласан иргэд, олон нийтийн төлөөлөлд янз бүрийн баталгаа, дэмжлэг үзүүлж үйл ажиллагааг нь идэвхижүүлсээр байна.

НЭГДҮГЭЭР ДЭД СЭДЭВ

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТ ӨНӨӨДРИЙН БАЙДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

Өнөөдрийн төлөв

Авлигатай тэмцэх газрын цахим хуудаст тогтмол мэдээлж байгаагаас дундажлан үзвэл АТГ-г 7 хоногт авлигатай холбоотой байж болзошгүй 30-50 мэдээлэл ирдэг юм байна. Мөн хүлээж авсан гомдол мэдээллийн дийлэнхи олонхи нь хэрэг үүсдэггүй юм байна гэж хэлж болохоор байна.

- Зарим нь гэмт хэрэг биш, захиргааны болон санхүүгийн журмын зөрчил
- Зарим нь харьяаллын бус хэрэг
- Зарим нь эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт тооцох хохирлын хэмжээнд хүрэхгүй

байдаг байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн оролцооны хэлбэр нь:

- а. Иргэн мэдээлэл өгөх
- б. Иргэн өргөдөл, гомдол гаргах
- с. Төрийн болон төрийн бус байгууллага, түүний албан тушаалтнаас мэдээлэл өгөх
- д. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, бичих, нийтлэх, уриалах, сэрэмжлүүлэх
- е. Төрийн болон төрийн бус байгууллагын сургалт, зөвлөмж,

Авлигын тохиолдлын талаар болон урьдчилан сэргийлэх олон нийтийн оролцооны арга нь:

- а. Утсаар
- б. Цахимаар
- с. Бичгээр

Урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцох оролцооноос үүсэх үр дагаварын сөрөг нөлөөллөөс хамгаалах баталгаа:

- а. Нууцлал байдаг эсэх – байдаг

- b. Аюулгүй байдлыг хангадаг эсэх - аюулгүй байдлыг хангадаггүй
- c. Хамгаалалт байдаг эсэх - байхгүй

Авлигаас урьдчилан сэргийлэх үй ажиллагаанд олон нийтийн хяналт оролцооны идэвхи, санаалчлага, хөдөлмөрийг эдийн засаг, санхүүгийн хувьд хэрхэн шийдсэн байдаг талаар

- a. Гэмт хэргийн талаарх мэдээллийг санхүүгийн нэгжээр эсэх – үгүй
- b. Мэдээллийг худалдаж авдаг эсэх – үгүй
- c. Бусад эдийн засгийн урамшуулал, идэвхижүүлэт байдаг эсэх – үгүй

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо нь чухал, харин түүнд хяналт тавих төдийлөн шаардлагагүй юм. Харин авлигатай холбоотой хэргийг шалгах, мөрдөх, хянан шийдвэрлэх явцад хөндлөнгийн нөлөөлөл их байдаг гэсэн хардлага байдаг учраас үе шат бүрд олон нийтийн зүгээс хяналт тавих шаардлагатай байдаг. Харин энэ тал дээр манай хуулийн процесст нээлттэй зүйл байхгүй. Олон нийтээс нууцалсан байдалтай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсээр дуусдаг.

Шийдвэрлэвэл зохих асуудал, үр нөлөө.

Авлигын эрсдэл бүхий субъект, авлигын гэмт явдал гүйцэтгэж байгаа субъект нь хуулиар олгогдсон эрх мэдэлтэй, өндөр түвшний нөлөөлөлтэй, албан тушаалын хамаарал ихтэй, гэмт хэрэг үйлдэж байгаагаа бүрэн ухамсарласан, бэлтгэсэн сэдэлтэй байдаг тул тэдгээрийн гэмт явдлын талаар эсрэг сонирхолтой этгээдэд эрсдэл үүсч байдаг. Авлигын талаар шүгэл үлээж, нийгэмд хонх цохиж байгаа субъектыг хамгаалах, түүний аюулгүй байдлын баталгааг хангах хуулийн зохицуулалт хэрэгтэй. Нөгөө талаар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцоо, хяналтыг сайжруулах үйл ажиллагааг идэвхижүүлэхийн тулд урамшуулах арга хэрэглэх нь үр дүнтэй.

Авлигаас урьдчилан сэргийлэхэд тулгамдсан шийдвэрлэвэл зохих асуудалд “олон нийтийн оролцооны баталгаа, урамшууллын хууль зүйн зохицуулалт”-ыг нэрлэж байна.

ХОЁРДУГААР ДЭД СЭДЭВ
АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫГ ИДЭВХИЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах хөшүүрэг, эрх зүйн зохицуулалт, аргазүйн талаар дэвшүүлэх нь:

- Эрхзүйн хэлбэр/арга/
- Эрхзүйн бус хэлбэр/арга/
- Эдийн засгийн хэлбэр/арга/

Эрх зүйн хэлбэр/арга/:

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, мөн түүнчлэн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд үүрэг хүлээсэн байгууллагаас гадна өөрийн сайн дураар, журамт үүргийнхээ дагуу оролцож байгаа иргэд, олон нийтийн төлөөллийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах, тэдгээрийг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, хувийн мөрдөлт хийх, мэдээлэл өгөх зэрэгт нь хуулийн зохицуулалт хийж, зарим эрхийг олгож, хуулиар хамгаалах, тэдэнд аюулгүй байпдлын баталгаа гаргаж зохицуулах хэрэгтэй юм.

Эрхзүйн бус хэлбэр/арга/

Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтийн оролцоотойгоор, авлигын эрсдэл бүхий субъектэд хяналт тавихад иргэд, олон нийтийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудад мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хаана, хэзээ, хэрхэн, ямар субъект авлигын эрсдэл бүхий нөхцөлд орж болох уу. Түүнд хэрхэн хяналт таих уу гэх мэт.

Энэ ажлыг хийхэд холбогдох хууль сахиулах байгууллагад мэдээлэл дэмжуулах, хэрэв боломжгүй бол өөрөө хувийн мөрдөлт хийх, папараци, ийм ажил зохион байгуулахад нь зөвлөгөө туслалцаа үзүүлэх, бүр энэ төрлийн сургалт зохион байгуулах нь авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг мэргэжлийн талруу нь оруулж, илүү үр дүнтэй болгох юм.

Эдийн засгийн хэлбэр/арга/

Авлигын эсрэг мэдээлэл өгсөн, чухал мэдээлэл олж авсан, өөрсдөө илрүүлж баримтжуулсан иргэд, олон нийтийн төлөөлөлд тухайн хэргийн эдийн засгийн хор хохиролоос нь тооцож урамшуулал олгох, мэдээллийг мөнгөн дүнгээр үнэлж худалдаж авах нь гадаадын зарим улс оронд олон нийтийн оролцоо, хяналтыг идэвхижүүлэх шалгарсан арга болоод байна. Үүнийг тусгаж авч хуульчлан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг идэвхижүүлэх эдийн засгийн аргад:

- a) Мэдээлэлд урамшуулал тооцож олгох
- b) Мэдээллийг мөнгөн дүнгээр үнэлж худалдаж авах
- c) Цалинг нь нэмэгдүүлэх
- d) Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх
- e) Бусад эдийн засаг, санхүүгийн арга хэрэгсэл

Бусад баталгаа: Ажлаас нь халж болохгүй хугацаа тогтоох, тодорхой хугацаанд хамгаалалтад авах, нууцлалын зэрэглэлийг өндөржүүлэх гэх мэт баталгааг хуульчлан зохицуулах хэрэгтэй.

ХАВСРАЛТ ДЭД СЭДЭВ

АВЛИГЫН ЭСРЭГ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУСГАЛ

Эрүүгийн хуулийн 263, 264, 265, 266, 267, 268, 270, 273 дугаар зүйлүүдэд хохирлын хэмжээг заасан байна. Авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ хохирлын хэмжээний хязгаарт хүргэхгүй л бол гэмт хэрэг гэж тооцохгүй, эрүүгийн хэрэг үүсгэхгүй байх нь. Жишээ нь эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлд төсвийн хөрөнгийг зорулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг үйлдсэн үед 9.4 сая төгрөгт хохирлын хэмжээ хүрэхгүй бол гэмт хэргийн бүрэлдэхүүн хангахгүй гэж үзэхээр байна.

Энэ бол авлигачийг авлига авахыг хуулиар зөвшөөрсөн, авлига авах эрх олгосон хуульчлал юм. Дээрх заалтууд тус бүр хохирлын хэмжээ заасан байдаг. Тэрхүү хохирлын хэмжээн дотор энэ нэр төрлийн гэмт хэргийг үйлдэх эрх нь бүх албан тушаалтнуудад бии.

Авлига бол социал утгаараа нийгмийг хохироодог гэмт хэрэг тул түүнээс материаллаг бүрэлдэхүүн шаардах нь утгагүй юм. Энэ бол цэвэр хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Хууль зүйн утгаараа ч шууд санаатай үйлдэгддэг.

Мөн нөгөөтэйгүүр хуульд хохирол тооцохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харгалзан үзэх нь оновчтой биш. Хохирлыг тухай бүрд нь тухайн цаг материалын үнэлгээг тооцож хийх нь зүйтэй юм. Тухайлбал 2002 онд одоогийн мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийг батлахад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин, зуун хорин тав дахин үржүүлэхэд тухайн үеийн улс орны эдийн засаг, иргэдийн орлогын байдалтай харьцуулахад асар их тоо байсан. Харин өнөөдөр улсын эдийн засаг тэр үеийнхээс ойролцоогоор 12 дахин өссөн, иргэдийн орлого эрс өссөн, бараа бүтээгдэхүүний үнэ ч эрс өөрчлөгдсөн зэрэг олон талын үзүүлэлт нь өнөөдрийн эрүүгийн хууль дах Авлигын гэмт хэрэгтэй холбоотой зүйл заалтуудыг өөрчилж, сайжруулж, боловсронгуй болгохыг шаардаж байна.

ДҮГНЭЛТ

- Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд чухал байр суурьтай гэсэн үүднээс “Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцооны эрх зүйн зохицуулалтын үзэл номлол” бий болгоё.
- Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн хяналт, оролцооны арга, хэлбэрийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн нууцлал, аюулгүй байдал, хамгаалалтыг хуульчлан зохицуулдаг болоё.
- Авлигатай холбоотой үндэслэл бүхий мэдээллийг мөнгөн дүнгээр үнэлж хууль сахиулах байгууллага иргэд, олон нийтээс худалдаж авбал олон нийтийн авлигын эсрэг үйл ажиллагаа бодитой идэвхижнэ.
- Гадаад улс орнуудын энэ тал дээрх ололттой талыг тусгаж хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Эрүүгийн хуулийн зарим зүйл заалтад үнэлэлт, дүгнэлт өгч өөрчлөлт оруулах шаардлагатай болжээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. АТГ-н цахим хуудас/эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, нийтлэл цэс/
2. Wikipedia, google /гэмт хэргийн статистик мэдээ/
3. УЕПГазрын цахим хуудас
4. Монгол улсын эрүүгийн хууль
5. Өөрийн судалгаа, тэмдэглэлийн хувийн материалуудаас